



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Утас: 32-03-92, Факс: (976-11) 31-14-71
<http://www.mongolbank.mn>

2023.10.09 № А-7/886
танай _____-ны № _____-т

Зөвшөөрлийн тухай


Танай байгууллагын аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрлийн хүсэлтийг хянаж үзлээ.

Албан бичгийн хавсралтаар ирүүлсэн баримт бичгүүд нь Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон Монголбанкнаас баталсан Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журамд заасан шаардлагыг хангасан тул Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А-185 дугаар тушаалаар танай байгууллагад аутсорсингийн үйлчилгээ авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 4 (дөрөв) жилийн хугацаатай олгосныг үүгээр мэдэгдэж байна.

Аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрлийн баримт бичигт дурдсан байгууллагаас өөр гуравдагч этгээдээс аутсорсингийн үйлчилгээ авах тохиолдолд Монголбанкнаас заавал дүгнэлт гаргуулах шаардлагатай болохыг сануулж байна.

Хавсралт 1 хуудастай.

ТӨЛБӨР ТООЦООНЫ
ГАЗРЫН ЗАХИРАЛ



Э.АНАР

1523023065



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2021 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А-185

Улаанбаатар хот

Аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрөл олгох тухай

Төв банк(Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ард кредит ББСБ ХК-нд аутсорсингийн үйлчилгээ авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 4 (дөрөв) жилийн хугацаагаар олгосугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Төлбөр тооцооны газар (Э.Анар)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1523011841